

ТОТЕМИЗМ БА МОНГОЛЧУУДЫН ТОТЕМ ШҮТЛЭГ

С.Хишигтогтох, доктор (Ph.D)

Ховд Их Сургууль

Нийгэм, хүмүүнлэгийн ухааны тэнхим

Түлхүүр үг: Эрхтний шашин, тотемизм, шүтээний амьтан, хорио цээр (табу), зан үйл, дом (маги)

Эртний үеийн шүтлэгийн хэлбэрүүд улс үндэстний шашин, соёлын тогтолцоонд зохих байр суурьтайгаар уламжлагдсаар, түүний ул мөр эдүгээ хүртэл хадгалагдан үлдсэн нь бий. Монгол угсаатны хувьд фетишизм, маги, тотемизм, анимист шүтлэгүүд ард түмний итгэл үнэмшилд ямар нэг байдлаар оршиж, тэдний ахуй соёл, зан үйлээр дамжин эдүгээ ч хэрэглэгдсээр байна. Бид энэхүү өгүүлэлдээ Тотемизм нь соёлын нэг үзэгдэл болохынхоо хувьд ямар байр суурьтай вэ, Монгол угсаатны шашин, соёл дахь тотем шүтлэгийн амьтан болох (чоно), түүний талаарх Монголчуудын төлөөллийн тухай товч өгүүлнэ.

Үндсэн хэсэг: Тотемизм нь ямар нэгэн бүлэг хүмүүс, адгуусан амьтан, ургамал тодорхой зүйлтэй нэгэн гарал үүсэлтэй, мах цусны холбоотой гэдэгт итгэж бишрэх эртний шүтлэгийн нэг хэлбэр юм. Шүтлэгийн энэ хэлбэр анх Австрали, Хойт ба Өмнөд Африк дахь овог аймгийн дотор дэлгэрчээ. Ямар нэг шүтээн (тотем) нь улс үндэстэн, овог аймгуудын нэгдэл, нягтралын бэлгэдэл, нэг гарал үүсэлтэйг илтгэх үндсэн үүрэгтэй байжээ. Нэг тотем шүтлэгтэй овогийн дотоод зохион байгуулалтын үндэс нь табу (хатуу хорио цээр) байв. Энэ үүднээс эртний нийгмүүдийн соёлын анхны үзэгдэл бол тотемизм мөн гэж үздэг.

Эрдэмтэд уг шүтлэгийг соёлын үзэгдэл болох талаас нь судалж, түүхийн хамгийн эртний соёлын үзэгдэл гэж тодорхойлж байна. Тотемизм нь хүн төрөлхтний хөгжлийг ойлгоход чухал ач холбогдолтойг

зарим судлаачид онцлон үзжээ. Английн антропологич Жеймс Фрейзер, Австрали, Меланез орчмын уугуул ард түмний дунд хийсэн антропологийн судалгаанд түшиглэн “...тотемизм бол эртний нийгмийг тайлбарлах цорын ганц зүйл, тотем нь тусдаа байгуулал бус, харин шашин болон нийгмийн үзэгдлийн алинтай нь ч холбогдох нэгэн цогц зүйл. Өөрөөр хэлбэл нийгмийн талаасаа шүтлэгийн систем, сэтгэл зүйн талаасаа шашны психологи” (Frazer, 1910, p.191) хэмээн өгүүлсэн. Английн угсаатны зүйч Гоулден Вайзер (1880-1940) “...тотем хүн төрөлхтний түүхийн хамгийн эртний үеийн цорын ганц соёлын үзэгдэл, шашны зан үйл, эгзогами ёс, бэлэгдэл зүй зэрэг соёлын элементтэй нарийн уялдаа холбоотой учир үүнийг судлах нь эртний соёлын хөгжлийг ойлгоход чухал ач холбогдолтой (Golden Weizer, 1970; 77) (Бадамхатан, 2012, хууд.15) гэжээ.

Нэг амьтныг тотем болгон шүтдэг бүлэг хүмүүс нэг гаралтай, тотем нь тэднийг авран хамгаалдаг гэж үзэх итгэл үнэмшил хөгжлийнхөө явцад зарим шүтлэгт өөрчлөгдөж ирсэн. Гэхдээ ихэнх шүтлэгт тотемын амьтны тухай ойлголт нэг угсаа гаралтай хүмүүст ураг төрлийн холбоог илэрхийлдэг утга нь хэвээр үлджээ. Хорио цээрийг судалсан томоохон эрдэмтэд болох В.Вундт, З.Фрейд, Ж.Фрейзер нарын үзэж байгаагаар “тотем шүтлэгтэй холбоотой хорио цээрээс ангид ард түмэн, соёл иргэншил гэж огт байдаггүй” (З. Фрейд, 2009, хууд. 98) гэнэ. Францын

соёлын философийн томоохон төлөөлөгч Клад Леви-Строс “...бид олон янзын угсаатны соёлоос нэг ижил хүчин зүйлийг олж хардаг. Түүнийгээ тотемизм хэмээн нэрлэдэг”(Леви-Строс, 1962, 45) гэсэн нь бий. Эрдэмтдийн тодорхойлсноос үзвэл тотем шүтлэг бол нийгэм, соёлын үзэгдлийн талаас нь ч, шашны сэтгэл зүйн үүднээс ч тайлбарлагдах соёлын чухал судлагдахуун юм. Нөгөө талаас хүн төрөлхтний язгуур шүтлэг болох тотемизмийг бидний үеийн шүтлэг бишрэл, соёлын тогтолцоонд үлдсэн ул мөрөөс мөшгөж үзэх боломжтой юм.

Тотем шүтлэгийг судалсан манай эрдэмтдээс С.Дулам “...эртний хүмүүс тотем шүтлэгийн амьтныг ураг төрлөө хэмээн үзэхийн үндэс нь тухайн үеийн нийгмийн чухал хүчин зүйл бол хүмүүсийн хамтын нэгдлийн асуудал байсан”(С. Дулам, 1989, хууд. 9) гэж тодорхойлжээ. Нэгэн төрлийн амьтан, ургамлыг ураг төрлөө хэмээн үзэх тотемизмийн үе шатыг бидний өвөг дээдэс туулж ирсэн нь түүхтэй. Хүн төрөлхтний ертөнцийг үзэх үзлийн энэхүү чухал үе шат бидний ухамсар, үл ухамсарлахуйд хэр гүн гүнзгий үлдсэнийг түүхэн баримт, судалгааны эх сурвалжид үндэслэн шинжлэх ухааны ноттой судалгааг манай эрдэмтэд хийсээр байна.

Угсаатан судлаач Б.Бадам-Оюу эртний нүүдэлчин үндэстэн тэр дундаа Монголчуудын уламжлалт шүтлэгийн мөн чанарыг нээхэд тотемийн дүрүүдийг судлах нь түлхүүр үүрэгтэйг дурдаад “... Монголчуудын тотем шүтлэгийн амьтад болох чоно, нохой, буга, баавгай зэрэг нь Европын орнуудад ч мөн эртнээс шүтэгдэж ирсэн. ...энэ мэт хэрэглэгдэхүүн арвин байгаа нь тотем шүтлэгийн үе шатууд дэлхий даяар ижил түвшинд явж ирснийг харуулж байна”(Б.Бадам-Оюу, 2016, хууд. 25) гэжээ. Тотемийн амьтны хувьд харилцан адилгүй, зарим угсаатнууд амьтнаас гадна мод, байгалийн бусад юмс үзэгдлийг тотемчлон шүтдэг байсан, эл шүтлэг нь

дэлхий дахинд түгээмэл байжээ.

Эх сурвалжаас үзэхэд “... Хүннү, Түрэг, Уйгар, Монгол зэрэг эртний улсуудын талаарх бичгийн болон археологийн дурсгалд чоныг тотемчлон үзэж, өөрсдийгөө түүнээс гарал угсаатай тухай өгүүлсэн мэдээ сэлт цөөнгүй”(С.Бадамхатан, 2012, хууд. 516). Монголчуудын гарлыг шууд чоно, маргал (буга) хоёртой холбон өгүүлсэн баримт “Монголын нууц товчоонд «Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ-чинуа, гэргий Гоа-Маралын хамт тэнгис далайг гэтэлж ирээд Онон мөрний эх Бурган Халдун ууланд нутаглаж...» (Д.Гонгор, 1978, хууд.68) хэмээн өгүүлдэг. Мөн уг эх сурвалжид “Чингис хаан ан авд мордох зарлиг буулгахдаа «Хоа марал, бөртэ чоно суманд орох буй, түүнийг бүү харва»” хэмээн анхааруулсан тухай мэдээ буй. Түүхч Г.Сүхбаатар “...бөөгийн шашны хөгжлийн дээд шатанд бөөгийн онго шүтээн нь тотем байснаа буурлын үе шатанд дээд өвгөдийг шүтэх шүтлэг болсон, ...тотемизм нь нүүдэлчин ард түмний дунд өвгөдийн шүтлэг хэлбэрээр үлдсэн”(Г.Сүхбаатар, 1982, хууд. 32) гэж үзсэн. Нэнэртний түүхтэй тотем шүтлэг нийгэм соёлын хэв маяг бүрд зохицон хувьсаж иржээ. Г.Сүхбаатар “Хүннү нарын домог урлагийн зүйлсийг харахад чоно, үхэр, марал тотемийн объект байсан нь Монголчуудад ч бас байсан юм (Г.Сүхбаатар, 1982, хууд. 32) гэжээ. Харин О.Пүрэв “эртний овог аймаг чоно, цагаан галуу, нарс мод, марал зэргийг өөрсдийн харсан тэнгэр хэмээн тахиж шүтсээр ирсэн. ... харсан тэнгэртэй ижил ойлголтыг тотем гэсэн үгнээс үндэслэн тотемизм хэмээн нэрлэсэн”(О.Пүрэв, 2002, хууд. 103) гэсэн байна. Үүнээс үзэхэд эртний Монголчуудын тотем шүтлэгт амьтнаас гадна, байгалийн зүйлс ч багтаж байжээ.

Хүн төрөлхтний хөгжил, шинжлэх ухааны мэдлэг, техникийн ололтууд тотем шүтлэг, хорио цээрийг өөрчилсөөр ирсэн. Шинжлэх ухаанжих үйл явц нь амьтныг

тотемчилох шүтлэгийн эл хэлбэрт ихээхэн нөлөөлсөн бөгөөд Монгол угсаатны хувьд бөөгийн шашинд шингэж үлдсэн байна. Тотем шүтлэгийн амьтан бөөгийн шашинд үлдэхдээ чоно, баавгай зэрэг хүчирхэг амьтны арьс, хумсыг зан үйлдээ хэрэглэх фетишизмийн агуулгатай болсон.

Энэ нь шашны зан үйл үйлдэхдээ тэдний хүчийг ашиглах утга санааг илэрхийлдэг. Гол төлөв харын бөө нар гурвалжин хэнгэрэг хэрэглэх бөгөөд чоно, баавгайн арьсаар бүрдэг. Хэнгэрэгийг харын онгодууд хараал жатга хийх, хар хэл ам дарах зэрэг хатуу үйлэнд ашигладаг ажээ. Учир нь тухайн хүчирхэг амьтан өөрийн хүч чадлаараа улаач бөөг үйлээ амжилттай гүйцэтгэх замч, унаа нь болдог гэж үздэг байна. Энэ нь тотемын амьтан ер бусын сүр хүчтэй, үр удамаа хамгаалж байдаг гэсэн эртний итгэл үнэмшлийг илэрхийлдэг. Чоно баавгай тотемтэй байсан Монголчуудын хувьд овог удмын улаач болох тухайн бөөгийн үйлийг гүйцэтгэж, бас хамгаалж буй утгатай юм.

Эртний нийгэмд үйлчилж байсан тотем шүтлэг, хатуу хорио цээр хөгжлийнхөө явцад цээрлэх ёсны соёл нэлээд ул мөрөө үлдээжээ. Монголчууд аж амьдрал, ахуй нөхцөлдөө цээрлэх ёсыг өдөр тутам мөрддөг ард түмэн гэж үзэж болно. Монгол хүн чоныг онгон шүтээнээ болгож байсны бас нэг нотолгоо бидний үеийн соёлд үлдэхдээ нэрийг цээрлэдэг ёсонд шингэжээ. Чонын нэрийг эерүүлэн “саарал нохой, гайхал, хангайн амьтан, хэцүү нэрт, тэнгэрийн нохой” гэхчлэн харилцан адилгүй цээрлэж нэрлэдэг.

Мөн чононд “ам гарч” болдоггүй” гэдэг. Энэ нь ямар нэг байдлаар чоныг “ална, хядна” хэмээн басамжилж, ам алдах, харааж зүхэхийг цээрлэн үздэг ёс юм. Хэрэв чононд ам гарвал хэзээ нэг цагт чонотой халз тулгарах эсвэл чононд хазуулж бариулах, мал сүрэгээ чононд идүүлэх аюултай байдаг.

Монголчуудын уламжлалт ёс заншилд амьтны тотемтэй холбогдолтой дом (маги)-ийн зан үйл цөөнгүй. Хүүхдийг муу юмнаас (аз зэтгэр, хий үзэгдэл) хамгаалж янз бүрийн сахиус зүүх явдал түгээмэл байсаар иржээ. Үүний нэг хэлбэр нь нялх хүүхдийг амь нас эрсдэхээс хамгаалж амьтны гаралтай зүйлээр дом хийх ёс юм. С.Бадамхатаны бичсэнээр “... чоныг тотем өвөг дээдсээ болгон үзэх төсөөлөл тогтдоггүй хүүхэдтэй (хүүхэд тогтдоогүй айл) холбоотой нэлээд зан үйлд уламжилж үлдсэн нь огт санамсаргүй зүйл биш бололтой. Тотем өвөг дээдсийн аль нэг зүйл ер бусын хүч чадалтай байдаг мэтээр үзэх, тотем амьтантайгаа цусан төрлийн холбоотой гэсэн ойлголт. Жишээ нь тогтдоггүй хүүхэдтэй айл хүүхдийн хүйг чонын шөрмөсөөр боож авах, чонын шагай, хоншоорыг хүүхдэд зүүхийг сайн гэж үзэх”(С.Бадамхатан, 2012, хууд. 512) зэрэг нь тотем шүтлэгийн амьтныг шүтэх итгэл үнэмшлийн үлдэц, ул мөр юм.

Чоныг дээдлэн үзэх эртний төсөөллөөс манай соёлд үлдсэн нэг хэлбэр бол мэргэ төлгө хийх зан үйл. Монголчууд ихэвчлэн есөн зоосны мэргэ, дөчин нэгэн чулууны мэргэ үйлддэг. Эдгээр мэргэ төлгийн аль алинд нь чонын дүр чухал байр суурьтай байдаг. Тухайлбал есөн зоосны мэргэ төлгөнд зоос бүр нэртэй бөгөөд “**чоно**” гэсэн зоос нь “*хийморьтой байх, эсвэл хэн нэгэн хүний тусламж дэмжлэг авахыг* илэрхийлж байх жишээтэй. Дөчин нэгэн чулууны мэргийг хийхдээ “*дөчин нэгэн чулуугаа толгой эгнээ, сав эгнээ, хөл эгнээ гэж гурван эгнээ таслах бөгөөд толгой эгнээнд гурав, гураваар есөн ширхэг чулуу таслагдвал үүнийг “гурав хөлөлсөн чоно” гэж нэрлэх бөгөөд аливаа мэргэ төлөгт ховор тохиолддог сайн төлөг, аз хийморьтой байх, аян зам, ирэх явахын тухай төлөгт маш хурдан байхыг илэрхийлдэг гэж үздэг.*

Орчин үеийн соёлд чоныг дээд шүтээн хэмээн төсөөлөх шүтлэгийн ул мөр амьтны эд эрхтэн, арьс үсийг хүнд байдаггүй ер бусын

хүч, шидтэй хэмээн үзэх фетишизмийн хэлбэрээр хадгалагдаж байна. Тухайлбал манай соёлд чонын шагайг аз хийморь, олз омог дагуулдаг хэмээн үзэж машин унааны түлхүүрт зүүх, хүлэг морь хурдан байхыг бэлгэдэж морины эмээл, ташууранд зүүх түгээмэл үзэгдэл байсаар байна. Мөн ан ав болон аян замд явахад чоно таарвал аз хийморьтой, ажил бүтэмжтэй байх нь хэмээн бэлгэшээдэг.

Орчин үеийн ард түмний дунд чоныг хийморьтой, хүчирхэг эсвэл ер бусын амьтан хэмээн дээдлэн үзэх үзэл байсаар байгаагийн нэг илэрхийлэл бол *"чоно өөрөөсөө илүү хийморьтой хүнд агнагдаж, өөртэйгээ ижил хийморьтой хүнд харагдаж, харин хийморь сүлд муу хүнд харагддаггүй тэнгэрийн амьтан"* хэмээн үзэх нь бий. Ингэж үздэг учир аян замд чоно таарвал ажил үйлс бүтэмжтэй хэмээн бэлгэшээж, энэхүү итгэл үнэмшил нь амьдралын туршлагаар нотлогдох нь цөөнгүй тааралддаг нь баримтаар нотлогддог.

Дүгнэлт

- Өөрийнхөө язгуур эх үндэс, ураг төрлийг мэдэх гэсэн аливаа угсаатан ард түмний эрмэлзлэлийн үр дүнд тотем шүтлэг бий болжээ. Эртний овогууд өөрийн өвөг дээдсийг ямар нэг хүчирхэг, ер бусын амьтан, ургамлаар төлөөлүүлэн төсөөлж, түүнийг дээд шүтээн болгон өргөмжилж шүтдэг байжээ.
- Амьтныг тотем болгон шүтэх шүтлэг түүхэн урт замыг туулж, янз бүрийн ард түмний соёлд харилцан адилгүй үлдсэн. Өөрийн эх үндэсээ мэдэх гэсэн жам ёсны оролдогын үр дүн болж нэн эртний Монгол угсаатан “чоно” мэт тэнгэрлэг, хүчирхэг, хийморьтой өвөг дээдэстэй хэмээн итгэж байсан нь эдүгээ ч бидний сэтгэлгээнд ямар нэг байдлаар хадгалагдсаар байна.

Ийнхүү чоныг тотем шүтээний амьтан болгон дээдлэх болсон нь Монголчууд өөрсдийгөө чонотой адилтган бэлгэшээх сэтгэлгэний илрэл байсан байж болох юм. Өөрөөр хэлбэл байгальтай зохицох чадвар, нарийн арга ухаан, баатарлаг байдлаа Монгол хүн чонотой адилтган үзэх төсөөллөөр өөрийн өвөг дээдсийг хөх чоно, марал буганаас гаралтай гэж үзэж байсан бололтой. Учир нь Монгол угсаатны хувьд бэлгэшээх үзэл, байгалийг шүтэх итгэл үнэмжил нэн эртнээс соёлын мөн чанарыг тодорхойлж ирсэн.

- Язгуур өвөг, уг гарлаа “чоно” хэмээн үзэх болсон нь ийм бэлгэшээх үзэл төсөөллийн биежсэн хэлбэр гэж үзэж болох юм. Тодруулбал монголчууд дээд язгуураа “чоно”, “буга” хэмээх хоёр амьтан эвцэлдээд монгол угсааны анхны хүнийг бий болгосон гэсэн шууд утгатай биш гэж ойлговол зохино хэмээн зарим судлаачид үзэж буй нь үнэний учиртай.
- Чоныг тотем болгон шүтэж ирсэн нь нэн эртний үеэс эхлэлтэй, түүхэн урт хугацааны замналтай ч хөгжлийн явцад анхны утгаа алдаж, шашин-соёлын зан үйлд үлдсэн. Тухайлбал Монголчуудын тотем шүтлэгийн тухай ойлголт бөөгийн шашинд өөрийн шинж байдлаа ихээхэн шингээсэн. Харин Тотем шүтлэгийн гол цөм болох табу (хатуу хорио цээр) эртний болон дундад үеийн хууль цаазад (табу)-гийн шинжээрээ оршиж, нийгэм соёлын зохион байгуулалтын гол хэмжүүр болж байжээ. Хөгжлийн явцад хууль цаазын шинж байдлаа алдаж ард түмний соёлд дагаж мөрддөг хэвшмэл зан үйлийн хэлбэрийг олжээ.
- Тотем шүтлэг түүнтэй холбогдох хатуу хорио цээр нь угсаатны соёлд зан үйлийн хэлбэрээр үлдэхдээ албадлын бус, ард түмний өөрийн хүслээр дагаж мөрддөг итгэл үнэмшлийг илүү хадгалж

үлдсэн.

- Эртний тотемын амьтаны төсөөлөлтэй холбоотой шашны зан үйлээс гадна, домын зан үйлээр хэрэглээнд нэвтэрч эдүгээ ч Монголчуудын дунд өөрийн байр сууриа хадгалсаар байна. Үүний учир гэвэл хүн язгуур сэтгэлгээ, язгуур соёл руугаа үл ухамсарлагдсан байдлаар тэмүүлж байдгийн нэг илэрхийлэл хэмээн үзэж болно.

Ном зүй

1. Бадамхатан С. Монгол улсын угсаатны зүй. УБ.,2012.
2. Гонгор Д. Халх товчоон I. УБ.,1978.
3. Дулам С. Монгол домог зүйн дүр. УБ.,1989
4. Леви-строс К. Тотемизм сегодня. Неприрученная мысль. М.,1962
5. Пүрэв О. “Монголын бөөгийн шашин. УБ.,2002.
6. Фрейд З. Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. УБ.,2009
7. Философийн толь. УБ.,1990.
8. Frazer, “Тотем ба экзогами” 1910, х.191)
9. Сүхбаатар Г. Монголчуудын эртний овог: Хүннү нарын аж ахуй нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал (НТӨ IV-МЭ II зуун) УБ.,1980.

Abstract:

Ancient religious forms have been handed down with a proper in the religion and culture of the nation. Traces of ancient religions are preserved even in modern religions. fetishism, magic, totemism, and animism existed In Mongolian religion for centuries. In this article, what is the position of totemism as a cultural phenomenon?. In the religion and culture of the Mongolian ethnic group, it is a totem worship animal (wolf), tells how Mongolians represent wolves.